

## БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ ГЭРЭЭ

"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.4, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас Дорнод аймгийн Баяндун сумын Засаг дарга Х.Хүрэлчuluун (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас "Улз Баяндун андууд" нөхөрлөл, (цаашид "Бичил уурхай эрхлэгч этгээд гэх)-ийг төлөөлж захирал Θ.Одхүү нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2018 оны 09 дугаар сарын 13-ны өдөр энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) Баяндун сум-д байгуулав.

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь Баяндун сумын Түргэн багийн Нүхт нэртэй газарт орших 5 гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу ..... жилийн хугацаагаар хайлуур жонш олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сүм (дүүрэг)-ын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна

### **Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Сумын Засаг дарга нь "Бичил уурхаигаар ашигт малтмал олборлох журам"-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2. хог хаягдлын цэгийн байршлыг тогтоох,

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;

2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдгэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх

2.1.5 бичил уурхайн ажилтнуудад (цаашид "ажилтан" гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах;

2.1.6. энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсох.

### **Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг**

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалыг ангилан ялгах баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химиин хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх.

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см<sup>3</sup> хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-осс илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11. бичил уурхаин нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах ..... / ..... / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах

3.1.13. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сүм, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх;

3.1.14. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах;

3.1.15. ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх;

3.2. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

### **Дөрөв. Харилцан хүлээх үүрэг**

4.1. Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

4.2. Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй. Сүм, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардана.

4.3. Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтаан тайлагнана.

### **Тав. Маргаан шийдвэрлэх**

5.1. Талууд гэрээтэй холбоогой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ

### **Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох**

6.1. Энэхүү гэрээ нь 2018 оны ... сарын ... өдрөөс 20 оны ... сарын ... өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

### **Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

Дорнод аймаг (хот)-ийн Баяндун сум  
(дүүрэг)-ын Засаг дарга

Х ХҮРЭЛЧУУЛУУН/

/Эцэг/ ЭХ/ ИИН НЭР НЭР ГАРЫН УСЭГ,  
тамга. тэмдэг/ /Пз Баяндун андууд " нөхөрлөл төлөөлж

УЛЗ БАЯНДУН

/Ө.ОДХҮҮ/

/Эцэг/ ЭХ/ ИИН НЭР НЭР ГАРЫН УСЭГ.  
тамга. тэмдэг/